



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/122

Эрдэнэт


┌ Тэмцээн зохион байгуулах тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1/a/, 29.1.5/a/, 29.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.3, 8.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2018 оны 03 дугаар сарын 06-наас 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын дунд зохион байгуулагдах “Багш лиг” гар бөмбөгийн тэмцээнд 3000000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 3000000 /Гурван сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал”-аас, гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ